



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 259 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам"-ын 1 дэх хэсгийн 3, 6 дахь заалт, тус яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөлийн ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөлийн ажиллах журам"-ын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Болор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.


БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



Л.ЭНХ-АМГАЛАН

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн
1/43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**



Зөвлөлийн дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд

Зөвлөлийн гишүүд

Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн гүйцэтгэх
захирал

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн гүйцэтгэх
захирал

“Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал

“Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал

“Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын
захирал


“И-Монгол академи” УТҮГ-ын захирал

“Мэдээлэл технологийн үндэсний парк”
ТӨААТҮГ-ын захирал

Зөвлөлийн нарийн
бичгийн дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
1/13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх, шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар сайдад зөвлөх үүрэг бүхий Сайдын зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Зөвлөлийн үйл ажиллагаа нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хэтийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль, журмын төсөл, нийтийн эрх ашгийг хөндсөн төсөл хөтөлбөр, сайдаас болон Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаас хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бусад асуудлыг хэлэлцэн зөвлөмж гаргахад чиглэнэ.
- 1.3 Зөвлөл яамны дотоод асуудлыг хэлэлцэхгүй.

Хоёр. Зөвлөлийн ажлын зохион байгуулалт

- 2.1 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх ба Сайдын зөвлөлийн хуралдааныг 2 сард нэг удаа хуралдуулна. Сайдын саналаар хугацааг тухай бүрд товлох ба ажлын зайлшгүй шаардлагаар товлосон хугацаанд хуралдааныг хийж чадахгүйд хүрвэл хугацааг өөрчилж, дахин товлоно.
- 2.2 Зөвлөл нь асуудлыг хамтын журмаар хэлэлцэнэ.
- 2.3 Сайдын зөвлөлийн хуралдаанаар дараах асуудлыг заавал хэлэлцүүлнэ:
 - 2.3.1 Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал;
 - 2.3.2 боловсруулсан хууль, журмын төсөл;
 - 2.3.3 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн төсөөлөл;
 - 2.3.4 төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын санал;
 - 2.3.5 цаг үеийн шинжтэй бусад асуудал.
- 2.4 Хуралдааныг Сайд удирдаж явуулна. Хуралдаанд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцож байгаа бол хүчинтэйд тооцно.
- 2.5 Хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны товыг Төрийн нарийн бичгийн даргын саналыг үндэслэн Сайд тогтоох бөгөөд хуралдааны бэлтгэл ажил, хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллээр зөвлөлийн гишүүдийг хангах үүргийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 2.6 Зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн төслийг Сайдад танилцуулж батлуулна.
- 2.7 Хуралдааны явцын талаар тэмдэглэл хөтлөх бөгөөд шаардлагатай бол хуралдаанаас зөвлөмж гаргаж болно.
- 2.8 Энэ журмын 2.7-д заасан зөвлөмжийг үндэслэн хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд Сайд, Төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаж болно.